



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/37

Дуурсах

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих  
нь Сургалтыг зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.5, Төсвийн тухай хуулийн 14.2.3. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 6/23 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн 2022 оны Хөгжлийн төлөвлөгөөний 2.1.1, Аймгийн Засаг даргын 2022 оны А/337 захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих нь” сэдэвт сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсугай.
2. Сургалтын удирдамжийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалтын үйл ажиллагаанд шаардагдах 2.000,000 (оёр сая төгрөг)-ийг нэмэлт санхүүжилтийн дансны үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас, 500.000 (таван зуун мянган төгрөг)-ийг үндсэн санхүүжилтийн дансны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас тус тус гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
4. Сургалтыг үр дүнтэй, чанартай зохион байгуулахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Г.Лхагва-Очир)-д даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д үүрэг болгосугай

ДАРГА  Н.ЭНХЖАРГАЛ





МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ



2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/337

Номгон

Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн сургалт  
зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 6/23 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн 2022 оны Хөгжлийн төлөвлөгөөний 2.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсугай.
2. Сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдах 2.000.000 (Хоёр сая) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.
3. Сургалтыг үр дүнтэй, чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т даалгасугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

601220830

БАТЛАВ  
НИЙГМИЙН УВООДЛОГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА *Б.Н* Б.НАРАНБАЯР  
2022 оны 05 дугаар сарын 05

0097332  
ГСТ7121 032100002

**“ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ НЬ” СЭДЭВТ  
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

2022.05.03.

Номгон

**Зорилго:**

Байгууллага хамт олон, гэр бүл, эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх

**Үйл ажиллагаа:**

- Батлагдсан хуваарийн дагуу сургалт, мэдээлэл зохион байгуулах
- Мэдлэг шалгах сорил авах
- Сургалтын гарын авлага, брошур тараах
- Гэр бүл, байгууллага, хамт олонд суурилсан эрүүл мэндийг дэмжих баг, клуб байгуулах

**Хамрах хүрээ:**

Аж ахуйн нэгж байгууллагын албан хаагч, иргэд

**Санаачлагч:**

Аймгийн Засаг даргын тамгын газар


**Хэрэгжүүлэгч байгууллага:**

Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Төрийн болон төрийн бус байгууллагууд

**Хугацаа:**

2022 оны 05 дугаар сарын 16-27-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

Эрүүл мэндийн газрын даргын *А.С* оны  
*А.С* дугаар сарын *12*-ны өдрийн  
*А.С* дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ЭРЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ НЬ СЭДЭВТ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

2022 оны 10 сарын 11 /Танхимын сургалт/		
Хугацаа	Сургалтын сэдэв	Сургалт заах багшийн нэр
<b>Сургалт</b>		
08.30-09.00	Сургалтын бүртгэл	ЭТХ-ийн мэргэжилтэн Ш.Одбаяр
09.00-09.10	Сургалтын нээлт	ЭМГ-ын дарга Н.Энхжаргал
09.10-09.30	Сургалтын танилцуулга, сургалтын өмнөх сонжуур	ЭТХ-ийн мэргэжилтэн Ш.Одбаяр
09.30-10.00	Зөв зохистой хооллолт	НЭМТ-ийн мэргэжилтэн Д.Мөнх-Эрдэнэ
10.00-11.00	Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд	НЭМТ-ийн мэргэжилтэн М.Баярбаясгалан
<b>11.00-11.15</b>	<b>Цайны завсарлага</b>	
11.15-12.00	Хөдөлгөөн эрүүл мэнд	НЭМТ-ийн мэргэжилтэн Ц.Амарсайнуу
12.00-12.40	Сургалтын дүгнэлт, ярилцлага	ЭТХ-ийн мэргэжилтэн Ш.Одбаяр
13.00-14.00	<b>Үдийн завсарлага</b>	
14.00-15.00	Халдварт бус өвчний талаарх ойлголт	НЭМТ-ийн мэргэжилтэн М.Баярбаясгалан
15.00-16.00	Хүнсний бүтээгдэхүүний сонголт	НЭМТ-ийн мэргэжилтэн Д.Мөнх-Эрдэнэ
16.00-16.15	<b>Цайны завсарлага</b>	
16.15-16.45	Дархлаажуулалтын ач холбогдол	НЭМТ-ийн мэргэжилтэн Д.Энхтуул
16.45-17.15	Сургалтын дүгнэлт, ярилцлага	ЭТХ-ийн мэргэжилтэн Ш.Одбаяр

----- о О о -----



Аймгийн Засаг даргын ..... оны ... дугаар  
сарын 05-ны өдрийн 1937 дугаар захирамжийн  
хавсралт

**“ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ НЬ” СЭДЭВТ  
СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Нэр төрөл	Шаардагдах хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Баннер	2	25000	50000
2	Хавтас	500	1000	500.000
3	Зөвлөмж брошур	500	1500	750.000
4	Санамж, гарын авлага	500	1400	700.000
5	Нийт дүн	2.000.000		

-----oOo-----